

**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ "УЛААНБААТАР СПОРТ МЕНЕЖМЕНТ" ХК-ИЙН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2026 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил		
1	2	3	4	5	6	7	8
Зорилго 1. Олон улс, тив, дэлхийн томоохон наадам зохион байгуулагдах стандартын шаардлага хангасан спортын тоног төхөөрөмж, хэрэглэлээр тоноглогдсон барилга байгууламжийг барьж, ашиглалтад хүлээн авна. Олон улсын болон дотоодын тамирчдад зориулсан зочид буудал барих.							
Зорилт 1. Спорт цогцолборын барилга, байгууламжийг бүрэн дуусгаж, ашиглалтад хүлээн авна.							
1	1.1.1. "Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор"-ын "Спортын төвийн барилга"-ын ажлыг үргэлжлүүлэх;	66,151.2	Гүйцэтгэлийн хувь	85%	100%	1. Тайлант хугацаанд барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай мэргэжлийн 3 дүгнэлт гарсан. Үүнд: - Барилгын А блокийн үндсэн металл багануудын суултыг тодорхойлох цикл хэмжилтийг геодезийн аргаар гүйцэтгэж, нэгдсэн дүгнэлт 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр; - Барилгын А блокийн хучилтын зураг төслийг дахин боловсруулж, Барилгын хөгжлийн төвийн 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 52/2026 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт; - Спортын барилгын ажлын өөрчлөлтийн болон хийгдээгүй ажлын шинэчилсэн төсвийг боловсруулж, магадлалаар оруулж Барилгын хөгжлийн төвийн 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 0514/2026 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлт тус тус гарсан. 2. Нийслэлийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/374 дүгээр захирамжаар "Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд хэрэгжиж буй "Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор"-ын "Спортын төвийн барилга"-ын ажлын гэрээг цуцалж, дүгнэх, акт үйлдэх, барилгын ажлыг үргэлжлүүлэх, эрчимжүүлэхтэй холбоотой санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь барилгын ажлын гэрээг цуцлахад шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулан санал, дүгнэлтийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж, түүнд үндэслэн "ӨВМТХ" ХХК-тай байгуулсан 2020 оны БЗ/20-01 дугаартай	100%
						2. Нийслэлийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/374 дүгээр захирамжаар "Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд хэрэгжиж буй "Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор"-ын "Спортын төвийн барилга"-ын ажлын гэрээг цуцалж, дүгнэх, акт үйлдэх, барилгын ажлыг үргэлжлүүлэх, эрчимжүүлэхтэй холбоотой санал, дүгнэлт гаргах" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь барилгын ажлын гэрээг цуцлахад шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулан санал, дүгнэлтийг 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдөр баталгаажуулж, түүнд үндэслэн "ӨВМТХ" ХХК-тай байгуулсан 2020 оны БЗ/20-01 дугаартай	100%

1	2	3	4	5	6	7	8
						“Цэнгэлдэх хүрээлэн, спорт цогцолбор”-ын “Спортын төвийн барилга”-ын ажлын гэрээг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөр цуцалж, гэрээг дүгнэсэн. 3.“Спорт цогцолборын спортын барилгын нэмэлт ажил”-ын тендер шалгаруулалтыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хариуцан зохион байгуулж, 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр цахим системээр зарлаж 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдөр нээж, Үнэлгээний хороо хуралдсан. Тендер ирүүлсэн нийт 2 оролцогч нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангаагүй татгалзсан шийдвэр гарсан.	40%
Зорилт 1.2. Олон улсын стандартыг хангасан спортын тоног төхөөрөмж, хэрэглэл худалдан авч суурилуулсан байна.							
2	1.2.1.Спорт цогцолборын спортын заалны тохижилт болон шаардлагатай тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн ажлыг дуусгаж, хүлээн авна.	-	Гүйцэтгэлийн хувь	90%	100%	Спорт цогцолборын спортын барилга угсралтын ажил бүрэн дууссаны дараа тоног төхөөрөмжийн суурилуулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд одоогоор барилгын ажлын гүйцэтгэлийг хүлээж байна.	50%
Зорилт 1.3. Олон улсын болон дотоодын тамирчдад зориулсан зочид буудал барих							
3	1.3.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлээр компанийн эзэмшлийн газарт барих зочид буудлын бэлтгэл ажлын хүрээнд “Улаанбаатар түншлэл төв” ХХК-тай хамтран ажиллаж, бичиг баримтын бүрдлийг хангана.	-	Гүйцэтгэлийн хувь	0%	100%	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх зочид буудлын төслийн бэлтгэл ажлыг хангаж, төслийн санал, танилцуулгыг 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Мэдээлэл хүргүүлэх тухай” 01/16 дугаар албан бичгээр, мөн зочид буудлын загвар зураг төслийг боловсруулж, 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр холбогдох байгууллагад тус тус хүргүүлсэн.	100%
3 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт-78%							
Зорилго 2. Спорт цогцолборыг спортын байгууламжийн менежментийн орчин үеийн системээр удирдан ажиллуулах, Монголын баг тамирчдад чанартай бэлтгэлийн орчин, мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээ үзүүлэх;							
Зорилт 2.1. Заал талбайн ашиглалттай холбоотой маркетингийн төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх							
4	2.1.1.Байгууллагын урт хугацааны тогтвортой түншлэлийг бэхжүүлэх, спортын барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, олон улсын болон дотоодын тэмцээн уралдааныг хүртээмжтэйгээр зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд спорт	-	Санамж бичгийн тоо	-	15	Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах боломжтой спортын холбоодын судалгаа, жагсаалтыг гаргаж, санамж бичгийг 2026 оны эхний хагас жил 7 байгууллагатай байгуулахаар төлөвлөснөөс 8 байгууллагатай байгуулсан.	100%

1	2	3	4	5	6	7	8
	холбоодтой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах;						
1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт-100%							
<i>Зорилго 4. Олон улс, тив, дэлхийн хэмжээний спортын наадам, фестивалийг зохион байгуулж, Монгол Улсын нэр хүндийг олон улсын тавцанд гаргах</i>							
<i>Зорилт 4.1. Нийслэл хотын нэрээр зохион байгуулах олон улсын хэмжээний тэмцээн, наадам, фестивалийн үзэл баримтлал, төслийг боловсруулж, хэрэгжүүлэх</i>							
5	4.1.1. "Олон улсын спортын ногоон наадам зохион байгуулах" төслийг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллана.	-	Боловсруулсан төслийн тоо	-	50%	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 147 дугаар тогтоолоор 2025 он хүртэл хойшлогдсон "Олон улсын спортын ногоон наадам зохион байгуулах" төслийг боловсруулахаар төлөвлөгөөнд тусгасан боловч одоог хүртэл ямар нэг эцсийн шийдвэр гараагүй тул энэхүү ажил хийгдээгүй болно.	0%
1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт-0%							
<i>Зорилго 5. Зорилтот бүлгийн иргэд, байгууллага, хамт олныг спортын хөтөлбөр, арга хэмжээгээр дэмжиж, нийгмийн эрүүл мэнд, идэвхтэй амьдралыг дэлгэрүүлнэ.</i>							
<i>Зорилт 5.1. Зорилтот бүлгийн иргэдийн биеийн тамир, спортын хэрэгцээнд зориулсан төсөл, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх"</i>							
6	5.1.1. Гудамжны спортын фестиваль-2026 4 удаагийн үйл ажиллагааг зохион байгуулна.	18,933.0	Хэрэгжилтийн хувь	-	100%	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороотой хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн "Эрүүл, спортлог Чингэлтэйчүүд" гудамжны спортын фестивалийн бэлтгэл ажлыг хангаж, удирдамж батлуулсан. Тус арга хэмжээнд спортын 5 төрлөөр, 7 насны ангилалд 24 хороо, ерөнхий боловсролын сургуулиуд болон харьяа байгууллагын 1,500 гаруй оролцогчийг хамруулахаар төлөвлөсөн боловч хамтран зохион байгуулагч талаас тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. Мөн "Гудамжны спортын фестиваль-2026" цуврал арга хэмжээний бэлтгэл ажлын хүрээнд 3 дүүргийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох спортын холбоодтой уулзалт зохион байгуулж, хамтран ажиллах талаар урьдчилсан зөвшилцөлд хүрсэн.	80%
7	5.1.2. Асрамжийн газрын хүүхдүүдийг оюуны спортоор чадавхжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайлагнана.	-	Сургалтын тоо	-	2	Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хороонд байрлах "Хүүхдийн баясгалан" хүүхэд хөгжлийн төвтэй хамтран "Го-даам" -ын сургалт 2026 оны 06 дугаар сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулах хөтөлбөрийг батлуулж, бэлтгэлийг ханган ажиллаж байна.	70%

1	2	3	4	5	6	7	8
1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт-75%							
<i>Зорилт 5.2.Иргэд, байгууллага, хамт олныг спортоор дамжуулан бүтээмжтэй, идэвхтэй иргэн болгох, байгууллага, хамт олонд үнэ цэнэ өгөх төсөл, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх</i>							
8	5.2.1. Спортын секц, клубүүдийн мэдээллийн сайт хөгжүүлэх ажлын хүрээнд секц, клубүүдийн мэдээллийг үүсгэж байршуулна.	-	Байршуулсан мэдээллийн тоо	120	180	Спортын секц, клубүүдийн мэдээллийн цахим сайт хөгжүүлэх ажлын хүрээнд эхний хагас жил 90 сургалтын байгууллагын мэдээллийг оруулахаар төлөвлөснөөс 60 байгууллагын мэдээлэл байгууллагын цахим хуудаст байршуулсан.	100%
9	5.2.2.Спортын секц, клубүүдийн мэдээллийн сайт хөгжүүлэх ажлын хүрээнд секц клубүүдийн үйл ажиллагааг таниулах видео контент бэлтгэж, олон нийтэд хүргэнэ.	-	Видео контентийн тоо	-	3	Спортын секц, клубүүдийн мэдээллийн цахим сайт хөгжүүлэх ажлын хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч, контентын агуулгыг боловсруулж, 3 контентийг бэлтгэж ажилласан.	50%
1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт-75%							
ХОЁР:ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД							
<i>Зорилго 6.Хууль тогтоомж, Засгийн газрын болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангаж ажиллана.</i>							
<i>Зорилт 6.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, холбогдох хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, стандарт, дүрэм журмыг батлуулж, хэрэгжүүлэх үйл явцыг зохион байгуулах</i>							
10	6.1.1. Байгууллагын 2026 оны бизнес төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95.1	100	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 27-ны ээлжит анхдугаар хурлаар байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийг батлуулж, 2026 ооны 06 дугаар сарын 08-ны байдлаар батлагдсан төсвийн 30 хувийг зарцуулсан.	100%
11	6.1.2.Төсвийн шууд захирагч Нийслэлийн засаг даргатай байгуулсан "Хариуцлагын гэрээ"-ий хэрэгжилтийг хангуулж биелэлтийг нэгтгэн хагас, бүтэн жилээр дээд газарт тайлагнаж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	95.1%	100%	Компанийн Гүйцэтгэх захирал Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр 01/83 дугаартай "Хариуцлагын гэрээ"-г байгуулсан. Гэрээний хүрээнд нийт 12 зорилт, 29 арга хэмжээ хэрэгжүүлэхээс хагас жилийн байдлаар 17 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 12 арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд 1 арга хэмжээ нь хугацаа болоогүй, нэмэлтээр 2 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.	75%
12	6.1.3.Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох гүйлгээ, тайлан мэдээ, тушаал шийдвэрийг стандарт, журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулж тайлагнах;	-	Шилэн дансанд байршуулсан мэдээллийн тоо	154	65	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд shilendans.gov.mn-д "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу 2026 оны 1 дүгээр улирлын тайланг хугацаанд нь байршуулж,	100%

1	2	3	4	5	6	7	8
						нийт 154 мэдээллээс 80 мэдээллийг байршуулж тайлагнаж 55 хувиар үнэлэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 35 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү системд тайлангийн хугацаанд байгууллагын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд гарсан шийдвэр, орлого зарлага, худалдан авалтын 95 мэдээ байршуулахаас 65 мэдээг байршуулсан.	
13	6.1.4.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангаж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50	1.Тайлангийн хугацаанд байгууллагын нийт орлого 101,995.36 мянган төгрөг болж, үүнээс хүүгийн орлого 83,551.37 мянган төгрөг, үйл ажиллагааны түрээсийн орлого 9,150.0 мянган төгрөг, бусад орлого 95.0 мянган төгрөг, авлага 9,198.92 мянган төгрөгийг бүрдүүлсэн. 2.Мөн нийт 1,143,538.85 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан. Үүнд: цалингийн зардал 547,747.67 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 62,043.55 мянган төгрөг, байр ашиглалтын тогтмол зардал 177,075.24 мянган төгрөг, бусад үйл ажиллагааны зардал 356,672.38 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.	100%
14	6.1.5.Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдсон үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг тайлагнаж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100%	100%	Байгууллагын эзэмшлийн спортын тоног төхөөрөмж, хэрэглэл материалыг ашиглуулах болон түрээслэх 29 гэрээг нийт 29 байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, гүйцэтгэлд ажилласан. Үүнд: -Монголын волейболын холбооны "Хөгжлийн лиг" тэмцээнд волейболын шал ашиглуулах; -"Монголын спортын шийдэл" ХХК-тай "Улаанбаатар кап" тэмцээнд ашиглах волейболын шал, хэрэглэл материалыг түрээслэх гэрээ байгуулж, 650,000 төгрөг, мөн Монголын жүдо бөхийн холбооны өсвөр үеийн УАШТ-д татами болон хөлийн LED дэлгэцийг түрээслэх гэрээ байгуулж, 8,500,000 төгрөг буюу нийт 9,150,000 төгрөгийг байгууллагын төсөвт төвлөрүүлсэн.	100%
15	6.1.6.Байгууллага, нэгж, албан хаагчийн зорилт ба шалгуур үзүүлэлтийг хөгжлийн бодлоготой уялдуулж, KPI-д суурилсан үнэлгээний	Дотоод эх үүсвэр	Үнэлгээний тоо	-	-	Байгууллага, нэгж, албан хаагчийн зорилт болон шалгуур үзүүлэлтийг байгууллагын хөгжлийн бодлоготой уялдуулан шинэчилж, KPI-д суурилсан гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоогоор гүйцэтгэлийг үнэлэх ажлыг хэрэгжүүлж байгаа	100%

1	2	3	4	5	6	7	8
	тогтолцоогоор гүйцэтгэлийг үнэлнэ.					бөгөөд албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр үнэлж, 2026 оны 06 дугаар 10-ны байдлаар 19 албан хаагчид нийт 62,422,868,0 ур чадварын урамшууллыг олгосон.	
16	6.1.7.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган, мөрдөж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Холбогдох хууль, журамд нийцүүлэн 2026 оны төсөвт холбогдох зардлыг тусгаж, ХАБЭА-н төлөвлөгөөг батлуулж, “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх комисс” байгуулсан бөгөөд цаашид ХАБЭА хариуцсан ажилтны орон тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.	50%
17	6.1.8.Дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангаж ажиллана.	-	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь	-	50%	Байгууллагын чиг үүрэгт хамаарал бүхий дээд газраас ирсэн хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг нийт 7 шийдвэрийн 8 заалтын биелэлтийг 2026 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж, Хяналт-шинжилгээ хариуцсан ажилтанд өгсөн. (Эхний улирлын тайланг 2026 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр НЗДТГ-т заасан хугацаанд хүргүүлсэн)	100%
18	6.1.9.Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангаж, дээд газарт тайлагнаж ажиллана.					Тайлангийн хугацаанд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд дараах тайланд хяналт-шинжилгээ хийж тайлагнасан. 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хагас жилийн байдлаар нийт 7 шийдвэрийн 8 заалтын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, 91.2 хувиар үнэлсэн. 2.Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.1.9 дэх заалтад “Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд хэрэгжиж буй Спорт цогцолборын спортын барилгыг үргэлжлүүлж ашиглалтад оруулах” ажил тусгагдсан бөгөөд тендер сонгон шалгаруулалт цуцлагдсан шалтгаанаар ажил хийгдэх боломжгүй болж, энэхүү ажилд хяналт шинжилгээ хийж, 40 хувиар үнэлж, НЗДТГ-ын холбогдох нэгжид тайлагнасан.	100%
19	6.1.10.Хотын хөгжлийн индекс дэх өөрийн байгууллагад хамааралтай индексийг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллана.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	Хотын хөгжлийн индексийн хүрээнд байгууллагад хамаарах үзүүлэлтүүдийг тодорхойлон, тэдгээрийг сайжруулах зорилгоор холбогдох арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	30%
				-	1	Үйл ажиллагаа, зохион байгуулалтын албаны даргын баталсан хөтөлбөрийн дагуу 2026 оны 03	100%

1	2	3	4	5	6	7	8
20	6.1.11.Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ажилтан албан хаагчдын хандлага ёс зүйг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.		Арга хэмжээний тоо			дугаар сарын 03-ны өдөр "Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага" сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийт 18 албан хаагч хамрагдсан бөгөөд сургалтаар харилцааны мөн чанар, бусадтай харилцах эв дүй, харилцааны арга барил, мөн төрийн үйлчилгээний стандарт, түүний шалгуур үзүүлэлт болон уялдаа холбооны талаар мэдлэг олгож, байгууллагын харилцаа, үйлчилгээний соёлыг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн үр дүнтэй сургалт болсон.	
1 зорилтын 11 арга хэмжээний хэрэгжилт-88%							
Зорилт 6.2.Ажилчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж бүтээмж өндөртэй хүний нөөцийг чадавхжуулна.							
21	6.2.1.Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө, 2026 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	-	50%	Байгууллагын нийт албан албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлэх, чадавхжуулах, үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай, идэвх санаачлагатай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангах зорилгоор "Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг боловсруулж, энэхүү хөтөлбөрийн хүрээнд хийж хэрэгжүүлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө"-ний хамт Гүйцэтгэх захирлын 2026 оны 03 дугаар сарын 26-ны А/07 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд эхний хагас жилийн тайланд хяналт шинжилгээ хийхэд 14 арга хэмжээг төлөвлөснөөс 9 арга хэмжээ хэрэгжиж, 7 арга хэмжээг хэрэгжээгүй учир үнэлгээнээс хасаж тооцсон.	94.1%
22	6.2.2.Байгууллагын дотоод болон гадаад (сонирхогч талууд) хэлэлцүүлэг зохион байгуулах тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх.	Дотоод эх үүсвэр	Арга хэмжээний тоо	-	1	Тайлант хугацаанд "Төслийн удирдлага хөгжлийн хүрээлэн"-тэй хамтран "Хөгжлийн стратеги төлөвлөлт, суурь судалгаа, санхүүгийн төсөөлөл" төслийн суурь судалгааны 4 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.	100%
1 зорилтын 2 арга хэмжээний хэрэгжилт-97%							
Зорилт 6.3.Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.							
23	6.3.1.Байгууллагын болон нийт албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалтад хяналт тавьж биелэлтийг хангуулан холбогдох	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50%	Гүйцэтгэх захирлын баталсан 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн А/51 дугаар тушаалаар сар бүр хяналт тавьж биелэлтийг хангуулж, үр чадварыг холбогдох журмын дагуу 5 удаа нийт 19 албан хаагчийн үр чадварыг үнэлж ажилласан.	100%

1	2	3	4	5	6	7	8
	журамд нийцүүлэн үнэлэлт, дүгнэлт өгнө.						
24	6.3.2.Байгууллагын чиг үүргийн хүрээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100	50%	"Жендерийн эрх тэгш байдлыг хангах" ажлын төлөвлөгөөг батлуулж, Монгол Улсын Засгийн газар болон Жендерийн үндэсний хорооноос 2026 оны 03 дугаар сарын 3-ны өдрөөс 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл үндэсний хэмжээнд уламжлал болгон зохион байгуулдаг "ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЭ" сарын аянд нэгдсэн.	100%
25	6.3.3."Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлнө.	346.140	Хэрэгжилтийн хувь	-	0%	"Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS 6395:2022 стандартын хэрэгжилтийн хүрээнд 427500 төгрөгийн үнэ бүхий "Хмон монгол бичгийн хөрвүүлэгч программ"-ыг 1 жилийн хугацаатайгаар худалдан авч, байгууллагын хэмжээнд 5 албан хаагч ашиглаж байгаа бөгөөд тушаал, тогтоол болон албан бичгийн хэвлэмэл хуудас (А4, А5) кирил болон монгол бичгийн хэвлэмэл хуудсын стандартын дагуу нийт 124 албан бичгийг кирил болон үндэсний хос бичгээр боловсруулж, албаны дарга нар хянаж, гүйцэтгэх захирлын тоон гарын үсгээр баталгаажуулж хүргүүлсэн.	100%
26	6.3.4.Албан хэрэг хөтлөлтийн eDoc системд бүртгэгдсэн албан бичгийн шийдвэрлэлт, зөрчлийн байдалд хяналт тавьж ажиллах, баримт бичгийн эргэлтийн болон хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг хагас, бүтэн жилээр гаргаж удирдлагуудад танилцуулна.	-	Хяналт хийсэн тоо	-	2	Тайлант хугацаанд нийт 120 албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавьж ажилласан бөгөөд энэ хугацаанд явцын тэмдэглэл хөтлөөгүй 6, хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн 3 зөрчил бүртгэгдсэн тул зөрчил гаргасан албан хаагчдад дахин давтан гаргуулахгүй байх талаар арга зүйн заавар өгч ажилласан. Мөн баримт бичгийн эргэлтийн болон хэвлэмэл хуудасны зарцуулалтын мэдээг батлагдсан маягтын дагуу гаргаж, гаргаж, нэгжийн дарга болон Ерөнхий менежерт танилцуулсан.	100%
27	6.3.5.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, БАЯАНЖ-ын дагуу Байгууллагын зохион байгуулалтын нэгжүүдээс 2025 оны үйл ажиллагаанд үүссэн баримтыг нягтлан шалгаж бүрэн	-	Хүлээн авсан баримтын тоо	61	64	Байгууллагын "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу 2025 оны баримтын бүрдлийг ханган, баталсан хуваарийн дагуу нийт 64 баримтыг хүлээн авч, байгууллагын архивд баяжилт хийсэн.	100%

1	2	3	4	5	6	7	8
	бүрдэлтэйгээр хүлээн авч байгууллагын архивд баяжилт хийнэ.						
1 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт-100%							
Зорилт 6.4.Нийслэлийн хэмжээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдыг авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлангийн чанарын үнэлгээ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээг дээшлүүлнэ. (НЗДҮАХ-5,1,14 НХТ-439)							
28	6.4.1.Байгууллагын чиг үүргийн хүрээнд "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023-2030 он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	-	Ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100	Байгууллагын "Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2026 оны 03 дугаар сарын 26-нд Гүйцэтгэх захирлаар батлуулж, эхний хагас жил 16 ажлыг хэрэгжүүлж, хэрэгжилт 100% биелэгдсэн. Компанийн удирдлага, албаны дарга нараас бүрдсэн эрх бүхий 6 албан тушаалтан Авлигын эсрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж мэдүүлсэн. Мөн авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Авлигатай тэмцэх газартай хамтран 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр "Авлигын тухай ойлголт, хууль тогтоомж, урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгуулж, компанийн нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан.	100%
1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт-100%							
Зорилт 6.5.Үйл ажиллагаандаа ил тод байдлыг бүрдүүлэх орчин нөхцөлөөр хангана.							
29	6.5.1.Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын web сайтад тавих шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, аюулгүй байдлыг ханган, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулна.	-	Мэдээллийн тоо	1	12	Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод байлгах хүрээнд байгууллагын чиг үүрэгтэй холбогдолтой шийдвэрүүдийг нэмж оруулахаар гадна вэйбсайт, цахим хуудас болон "ERP.ulaanbaatar.mn" системд нийт 13 удаагийн мэдээ, нийслэлд үйл ажиллагаа явуулдаг спорт 90 секц клубын мэдээллийг байршуулж, баяжилт хийсэн.	100%


1	2	3	4	5	6	7	8
30	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд	-	Тарьсан модны тоо	-	15	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, эко орчныг бүрдүүлэх үйл ажиллагаанд байгууллагын нийт албан хаагчид идэвхтэй оролцож, Сонгинохайрхан дүүргийн "Инчон мөрөөдлийн төгөл"-д 55 ширхэг нарс мод тарьж, байгаль орчноо хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулсан	100%
31	"Улаанбаатар марафон" олон улсын гүйлтийн өдөрлөгт оролцох	-	Оролцсон албан хаагчдын тоо	-	20	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдсан Олон улсын хэмжээний "Улаанбаатар марафон" нэгдсэн арга хэмжээнд байгууллагын нийт 18 албан хаагчид гүйлтийн 5 км-ийн төрөлд, 1 албан хаагч 21 км-ийн төрөлд идэвхтэй оролцсноор хамт олны эв нэгдэл, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлсэн үр дүнтэй үйл ажиллагаа болсон.	100%
1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт-100%							
11 зорилтын 33 арга хэмжээний хэрэгжилт-88.7 хувь							

ТАНИЛЦСАН:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХЯНАСАН:
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛТАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН



М. ТЭМҮГЭ

Э. БҮТЭД-ЭРДЭНЭ

Ц. ДУНГАРМАА

Г. ЦЭВЭЭНСҮРЭН